

## **МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтоох нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 5, 6 дахь хэсэгт зааснаар хууль тогтоогчийн бүрэн эрхийн хүрээнд хамаарах хэдий ч ийнхүү хуульчлахдаа Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалын хүрээнд тодорхойлогдсон Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус бусад таван гишүүнийг бусад институцээс тэнцвэртэй оролцооны үндсэн дээр нээлттэй нэр дэвшүүлэн, сонгон шалгаруулж томилох талаарх чиглэлийг баримтлаагүй нь шүүх эрх мэдлийн байгууллагын хараат бус байдал болон Үндсэн хуулиар баталгаажсан төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг алдагдуулах нөхцөлийг бүрдүүлжээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасан Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүний нэг хэсгийг сонгон шалгаруулж Улсын Их Хурал томилохтой холбоотой дээрх зохицуулалтууд нь Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороог хууль тогтоогч өөрийн мэдэлдээ бүрэн авч, шүүхийн боловсон хүчин, шүүгчийн сахилга, хариуцлагын асуудлыг хариуцсан Үндсэн хуулийн институтыг төрийн аль нэг эрх мэдлээс хараат бус байлгах чиглэлээр түүний эрх зүйн үндсийг бүрдүүлэх Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ умартаж, Үндсэн хуулиар өөрт олгогдоогүй эрх мэдлийг өөр бусад хуулиар хуульчлан авах замаар хууль тогтоох эрх мэдлийг явцуу зорилгоор хэрэгжүүлж, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн шүүх эрх мэдэлтэй холбогдох хэсгийн зорилго, агуулгыг бүрэн гажуудуулсан гэж үзэж байна.

## **МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн боловсрууллаа.

Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтоох нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 5, 6 дахь хэсэгт зааснаар хууль тогтоогчийн бүрэн эрхийн хүрээнд хамаарах хэдий ч ийнхүү хуульчлахдаа Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалын хүрээнд тодорхойлогдсон Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус бусад таван гишүүнийг бусад институцээс тэнцвэртэй оролцооны үндсэн дээр нээлттэй нэр дэвшүүлэн, сонгон шалгаруулж томилох талаарх чиглэлийг баримтлаагүй нь шүүх эрх мэдлийн байгууллагын хараат бус байдал болон Үндсэн хуулиар баталгаажсан төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг алдагдуулах нөхцөлийг бүрдүүлжээ.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны гишүүдийг Улсын Их Хурлын даргын захирамжаар, Улсын Их Хурлын гишүүнээр ахлуулан байгуулсан улс төрийн оролцоотой ажлын хэсгээс санал болгох замаар Улсын Их Хурал дангаар томилох нь шүүхийн боловсон хүчний бодлого, мөн түүнчлэн шүүхийн сахилга хариуцлагын асуудал улс төрийн нөлөөнд шууд автагдаж, үүний улмаас шүүх эрх мэдлийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал бүрэн алдагдах нөхцөл бүрдэж байна. Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүнийг нэр дэвшүүлэх ажлыг төрийн эрх мэдлийн нэг институт өөрөө эрхэлж сонгон шалгаруулаад, томилдог жишиг үндэсний болон олон улсын практикт байхгүй байна. Тодруулбал Улсын Их Хурал шүүхийн захиргаа, шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүнийг нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулж томилох эрхийг өөртөө авсан нь Улсын Их Хурлын хууль тогтоох чиг үүрэгт нийцэхгүй төдийгүй Үндсэн хуулиар баталгаажуулсан Улсын Их Хурлын үндсэн чиг үүрэгтэй харшилдах нөхцөл байдал үүсэж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд Улсын Их Хурлын чиг үүргийг тодорхойлохдоо Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална гэж заасан байдаг. Энэ нь хууль тогтоох замаар Үндсэн хуульд заасан шүүх болон гүйцэтгэх эрх мэдлийн хараат бус байдал руу халдах, хууль тогтоогчид хуулиар давуу эрх олгох агуулга

хөндөөгүй. Өөрөөр хэлбэл Улсын Их Хурал Шүүхийн Ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч биш гишүүдийн томилгооны үйл ажиллагаанд оролцох эрхийг хууль тогтоох замаар олж авсан нь Үндсэн хуулийн үзэл баримтлалыг гажуудуулах нөхцөлийг бүрдүүлсэн учир уг хуулийн төслийг боловсруулав.

Хуулийн төсөл, танилцуулгад олон нийтээс санал авахаар dparliament вэб сайтад 2023 оны 10 дугаар сарын 15-аас 11 дүгээр сарын 13-ны хугацаанд байршуулан нээлттэй хэлэлцүүлсэн.

-----oOo-----